



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/654

Алтай хот

Аймгийн аюулгүйн нөөцийн өвсний үнийг тогтоож, сумдад олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны А/136 дугаар захирамжаар батлагдсан "Гамшгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 4.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 216 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аюулгүйн нөөцийн саравчинд байгаа 5533 боодол өвсийг нэг бүрийг нь 4500 төгрөгөөр, агуулахад байгаа 7700 боодол өвсийг нэг бүрийг нь 9000 төгрөгөөр үнийг тогтоосугай.

2.Аймгийн аюулгүйн нөөцийн саравчинд багаа өвснөөс сумдад олгох өвсний тоо хэмжээг нэгдүгээр хавсралтаар, агуулахад байгаа өвснөөс сумдад олгох өвсний тоо хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвсний үнийн зөрүүг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн дагуу данс бүртгэлд тусгахыг нягтлан бодогч (Н.Наранцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Хуваарилагдсан өвсийг 2020 оны 11 дүгээр сард багтаан татан авч, цаг хүндэрсэн нөхцөлд малчдад худалдан борлуулж, хөрөнгийг аймгийн гамшгийн сангийн дансанд 5 дугаар сард багтаан төвлөрүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5.Өвсийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Л.Насанбуян), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т даалгасугай.


7.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/215, А/599, А/641 дүгээр захирамжуудыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2019 оны  
... дугаар сарын 25-ны өдрийн ... дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН САРАВЧИНД БАЙГАА  
ӨВСӨӨС СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ

№	Сумын нэр	Өвсний тоо /боодол/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/	Агуулахын байршил
1	Бигэр	500	4500	2250000	Аймгийн төвөөс
2	Дэлгэр	500	4500	2250000	
3	Тайшир	500	4500	2250000	
4	Халиун	500	4500	2250000	
5	Цогт	500	4500	2250000	
6	Чандмань	500	4500	2250000	
7	Эрдэнэ	500	4500	2250000	
8	Есөнбулаг	500	4500	2250000	
9	Төгрөг	250	4500	1125000	Шаргаас
10	Шарга	323	4500	1453500	
Дүн		4573		20578500	

\_\_оОо\_\_

Аймгийн Засаг даргын 2019 оны  
11... дугаар сарын...-ны өдрийн... дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН АГУУЛАХАД БАЙГАА  
ӨВСНӨӨС СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ

№	Сумын нэр	Өвсний тоо /боодол/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/	Тайлбар
1	Алтай	350	9000	3150000	Шарга сумаас
2	Баян-Уул	350	9000	3150000	
3	Бугат	350	9000	3150000	
4	Дарив	350	9000	3150000	
5	Жаргалан	350	9000	3150000	
6	Тайшир	500	9000	4500000	
7	Тонхил	350	9000	3150000	
8	Төгрөг	250	9000	2250000	
9	Халиун	500	9000	4500000	
10	Хөх морьт	350	9000	3150000	
11	Цээл	250	9000	2250000	
12	Шарга	250	9000	2250000	
13	Бигэр	500	9000	4500000	Аймгийн төвөөс
14	Дэлгэр	500	9000	4500000	
15	Цогт	500	9000	4500000	
16	Чандмань	500	9000	4500000	
17	Эрдэнэ	500	9000	4500000	
18	Есөнбулаг	250	9000	2250000	
Дүн		6950		62550000	

\_\_оОо\_\_